

**СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

8 дугаар сарын мэдээлэл

2024.08.23.

“Овоот”

Нэг. Төрийн удирдлагын чиглэлээр:

2024.08.23 ны өдөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал хуралдаж дараахь 3 асуудлыг хэлэлцэн баталж, тогтоол гаргасан. Үүнд:

1. 2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд нөөц өвс бэлтгэх зорилгоор Дарьгангын Байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс болох “Өндөр хүрээт”-ийн зүүн хойд талаас “Шар оноо”, “Хадат хүрээт” зэрэг 3500 га талбай бүхий газрыг ...

2. Сумын 2024-12-022-8866 дугаартай газар зохион байгуулалтын төлөвлөгөөг тодотгож, төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд 0.4976 га талбайтай нэгж талбарын газар зэрэг асуудал.

3. Орон нутгийн сонгууль болохтой холбогдуулан “Ухуулах самбар” байршуулах асуудал.

4. Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тохиолдын удирдлагын тогтолцооны багийг идэвхжүүлэн томилгоожуулж, эрүүл мэндийн нөөцийн бэлэн байлдлыг ханган, улаан бурхан өвчний тархалтаас сэргийлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх арга хэмжээг авч байна.

Хоёр. Сургалт сурталчилгааны чиглэлээр:

-Улаанбаатар хотноо 2024.08.14 ний өдөр зохион байгуулагдсан “Ардчиллыг бэхжүүлэх Иргэний нийгмийн байгууллагуудын зураглал” сэдэвт үндэсний хэлэлцүүлэгт сумын ЗДТг-ын Хууль эрх зүйн мэргэжилтэн биечлэн оролцлоо.



-Сүхбаатар аймагт 2024.08.22 ны өдөр зохион байгуулагдсан “Сэтгэлзүйн тулгамдсан асуудалтай иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх” сэдэвт сургалтад ЭМТ-ийн 2 ажилтан оролцож, мэдээлэл солилцлоо.

-“Малчны тухай хууль”-ийн дагуу 2024.08.12 ны өдрийг “Малчдыг сонсох өдөр” болгосонтой холбогдуулан тухайн өдөртэй уялдуулан 2024.08.18, 19 ний өдөр “Залуу малчдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, энэ үеэр олон талт арга хэмжээ авсны нэг нь тусгай хөтөлбөрөөр “Гурван түмэн адууны баяр”-ыг тэмдэглэсэн. Нийт 100 гаруй залуучууд зөвлөгөөнд оролцсон.

-Сүхбаатар аймгийн 13 сумын Ерөнхий боловсролын 16 сургуулийн сурлага, спортоороо бусдыгаа манлайлж байгаа нэг нэг сурагч буюу нийт 16 сурагчдыг Дорнод аймаг дахь Монгол, Зөвлөлтийн дайчдын хөшөө, дурсгал болон Халх гол суман дахь дайн, байлдааны ажиллагаа явагдсан газар орныг үзүүлэх, дайны ач холбогдол, туршлага сургамж болон туурга тусгаар тогтнолоо авч үлдэхийн тулд ямар их үнэ цэнээр олдсон, цаашид эх орныхоо тусгаар тогтнолыг хайрлан хамгаалах, эх орноороо бахархах үзлийг суулгах эх оронч үзлийг төлөвшүүлэн “Халх голын байлдааны ялалтын 85 жил”-ийн ойн тэмдэглэлт арга хэмжээнд оролцуулахаар шийдвэрлэсний дагуу 11 р ангийн 1 сурагчийг томиллоо.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Бог малын Мязан өвчлөлийн нийт дүн-3 өрхийн 138 мал

-Хорогдсон,устгасан-78

-Шинж тэмдэг арилсан-60

- Тусгаарлалтад -0

2024 оны 08 сарын 07 өдрөөс Бог малын мязан өвчний масс вакцинжуулалтыг эхлүүлж, сумын хэмжээнд 127066 бог мал дархлаажуулалтад хамруулахаас 2024.08.22 ны байдлаар : Өвчний голомтын бүсэд 40 өрх,

Сэжигтэй болон хамгаалалтын бүсэд-220 ний 260 өрхийн (хонь- 36745, хурга-7918, ямаа-27836, ишиг 3890) нийт 76389 толгой малыг тарилгад хамруулж гүйцэтгэл 60,1% -тай байна.

2024.08.23 ны өдөр өвсний нөөц бэлтгэх хадлангийн газрын асуудлыг 3500 га талбайд “Өндөр хүрээт”-ийн зүүн хойд талаас “Шар оноо”, “Хадат хүрээт” зэрэг газруудад шийдвэрлэв.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Сүхбаатар аймгийн ЭМГазрын мэргэжилтэнгүүд Улаанбурхан өвчний цаг үеийн нөхцөлтэй байдалтай холбогдуулан 7 хоног бүр цахим сургалтыг зохион байгуулж байгаа бөгөөд уг цахим сургалтын мэдээллийг баталгаажуулах , дадал болгох зорилгоор Эрүүл мэндийн төвийн эмч, ажилчдад Дотоодын сургалтыг тухай бүр нь зохих албан тушаалтанууд дамжуулан ажиллаж байна. Тухайлбал:

2023.08.14 ний өдөр “Улаанбурхан өвчин”, “Дархлаажуулалт” сэдвээр

2023.08.21 ний өдөр “Улаанбурханы халдвар сэргийлэлт, хяналт”, “Сорьц авах, хадгалах, тээвэрлэх “ зэрэг сэдвүүдээр мэдээллийг танхимаар болон цахимаар түгээсэн.

МУЗГ, ХБНГУЗГ хооронд байгуулсан хэлэлцээрийн хүрээнд Германы сэргээн босголтын банкаар дамжуулан, Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулах, орчны бүсийн сумдын иргэдийн тогтвортой амжиргааг дэмжих зорилгоор “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл II ,III хүрээнд Дарьганга Ерөнхий Боловсролын Эрүүл Мэндийн Төв Дарьганга бүрэн тоноглогдсон “АВТО МАШИН”-аа хүлээж авлаа.



Соёлын чиглэлээр:

“Сум орон нутгаа төлөөлөн дэлхийн өв соёлын "НҮҮДЭЛЧИН МОНГОЛ 2024" фестивалд Соёлын төвийн хамт олон болон Дарьганга сумын ЕБС-ийн багш, өв тээгч, монгол зураач Б.Энхмаа нүүдэлчдийн чухал өвийн нэг дарьганга нутгийн үлгэрийг олон нийтэд сурталчлан таниулж байна. Тэрээр Дарьганга үлгэрүүдийн үйл явдлыг монгол зургийн аргаар хар цагаанаар зурж, сонирхсон хүүхдүүд будаж болно. Мөн шавиараа үлгэр яриулж нийтэд түгээж байна.



Дарьганга сумын ОНХС-н хөрөнгөөр 18,8 сая төгрөгийн сандал ширээний баяжилт хийгдлээ. Үүнд: Сургалтын сандал 24ш, Сургалтын ширээ 20ш, Номын тавиур 4ш, Заалны сандал 50ш, Хурлын сандал 6ш, Дарга ширээ 1ш, Хурлын ширээ 1ш, Дугуйтай сандал 4ш хүлээн авч угсарч байрлууллаа.



Боловсролын чиглэлээр:

СӨБ ын болон Ерөнхий боловсролын салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн зорилгыг “СУРАЛЦАГЧИЙН ЭЗЭМШИХ ЧАДАМЖ (танин мэдэхүйн, эрүүл мэнд, нийгэм-сэтгэл хөдлөл)-ийг ХӨГЖҮҮЛЭХЭД БҮХ ТАЛЫН ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХАНГАЖ ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАНАР, ҮР ДҮНГ САЙЖРУУЛАХ”- аар дэвшүүлж, ЗОРИЛТЫГ 12 чиглэлээр батласныг нийтэд сурталчилж байгаа бөгөөд жилийн үйл ажиллагааныхаа төлөвлөлтөд уг зорилго зорилтыг үндэслэж байна.

-1 дүгээр ангид элсэн орох сурагчдыг E-MONGOLIA.MN цахим системээр 2024.08.12 ноос эхлэн бүртгэж байна.

-2-5 насны 315 хүүхдийг Сургуулийн өмнөх боловсролд суралцуулах ажлын хүрээнд бүртгэлийг хийж байна.

-Авлигатай тэмцэх газар, Боловсролын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газраас Төрийн байгууллагын удирдлага, ажилтан, албан хаагч, эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан 5 чиглэлийн 13 "ЗӨВЛӨМЖ"-ийг танилцуулж байгааг сумын ЕБС, Цэцэрлэгийн байгууллагаас нийтэд цахимаар танилцуулж байна.

-2024-2025 оны хичээлийн жилийн үйл ажиллагаатай холбогдуулан 0БС, Цэцэрлэгийн ажлын байрны сул орон тоонд сонгон шалгаруулалт хийхээр нийтэд зарыг хүргүүлээд байна.

-150 хүүхдийн хүчин чадалтай шинэ цэцэрлэгийн барилгын ажил хийгдэж, гүйцэтгэл 85 % тай байна.



ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
МЭРГЭЖИЛТЭН Д. МӨНХЗУЛ

ХЯНАСАН

СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ч. БАТБОЛД